

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.1-д заасны дагуу нийтийн өргөдлийн цахим системд иргэн Рэгзэнгийн Шинэгэрэлийн 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр байршуулсан PN-202503-75391 дугаартай Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-д заасан орлогод ногддог албан татварын хэмжээг 1% болгож бууруулах өргөдөл 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 100,187 иргэний санал авсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 3-т “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ”, Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.7-д “Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлнэ”, 2.1.2.10-д “Тогтвортой ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг татвар, эдийн засгийн бодлогоор дэмжинэ”, 2.1.3.11-д “Орлого багатай иргэдийн нэмэлт орлогын эх үүсвэрээс авах татварыг бодлогоор бууруулна”, 3.2.1.4-д “Бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах бодлого баримтална” гэж тус тус заан, хэрэгжүүлж байна.

1.2.Практик шаардлага:

Татварын бодлогын хувьд Монгол Улс өнөөдрийг хүртэл төсвийн зарлагыг санхүүжүүлэх татварын бодлого хэрэгжүүлж ирсэн. Сүүлийн жилүүдэд төсвийн зарлагыг санхүүжүүлэх зорилгоор төсвийн орлогыг өндрөөр төсөөлж тэр нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн хувьд ихээхэн дарамт болж байна. 2015 онд 6 их

наяд орчим байсан улсын төсвийн орлого 2025 онд 33.5 их наядаар батлагдаж, энэ хугацаанд 5.58 дахин өсөхөөр байна. Гэтэл 2015 онд 680.7 мянган төгрөг байсан голч цалин 2025 оны эхээр 2,229.4 мянган төгрөгт хүрч 3.27 дахин өссөн байна.

2024 оноос нийслэл хотын албан татвар 100%, цахилгаан эрчим хүчний үнэ 30% буюу түүнээс дээш, 2025 оноос автотээврийн хэрэгслийн албан татвар 200%, нийслэлийн автозам ашигласны төлбөр 400%, автотээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөр 100% тус тус нэмэгдсэн. Дулаан болон усны нэмэгдсэн үнэ тариф 2026 оноос үйлчилж эхлэнэ.

Үндэсний Статистикийн Хорооны 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр нийтэлсэн ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалингийн судалгаагаар 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар НДШ төлсөн 787.4 мянган ажиллагчдын 50 хувь нь голч цалин болох 2 сая 229 мянган төгрөгөөс бага цалинтай байна.

Үндэсний Статистикийн хороо Дэлхийн банктай хамтран 2024 оны 2 дугаар сард Монгол Улсын Ядуурлын түвшний үзүүлэлтүүдийг 2022 оны байдлаар танилцуулсан. 2022 он ядуурлын шугамын шинэ суурь он болсон. Ядуурлын шугам буюу нэг хүний нэг сарын хэрэглээ 2022 онд 418,045 төгрөг гэж тогтоогдсон. Насанд хүрсэн нэг хүнд ногдох хэрэглээний зардал нь ядуурлын шугамаас доогуур бол тухайн хүнийг ядуу гэж тодорхойлдог. 2022 оны байдлаар ядуурлын түвшин 27.1 хувьтай байгаа бөгөөд нийт 913.7 мянган хүн ядуу амьдарч байна. Ядуурлын шугамыг 15%-аар өсгөхөд хүн амын 10.3% буюу 346.8 мянган хүн ядууралд өртөхөд бэлэн байна.

Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн мэдээллээр 973,145 иргэн 1,981.4 тэрбум төгрөгийн татварын орлогыг цалингийн орлогоос, 96,532 иргэн 21.4 тэрбум төгрөгийн татварын орлогыг шууд бус орлогоос, 115,809 иргэн 79.9 тэрбум төгрөгийн татварын орлогыг үйл ажиллагааны орлогоос, 2,111,252 иргэн 341.6 тэрбум төгрөгийн татварын орлогыг хөрөнгийн орлогоос, 4,822 иргэн 23.0 тэрбум төгрөгийн татварын орлогыг хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогоос, 45,702 иргэн 2.6 тэрбум төгрөгийн татварын орлогыг бусад орлогоос тус тус 2024 онд улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Хувь хүний орлогын албан татварын орлогын 2024 оны дүнд цалингийн татвар 80.88 хувь, хөрөнгийн орлогын татвар 13.94 хувь, үйл ажиллагааны орлого 3.26 хувь, хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн орлого 0.93 хувь, шууд бус орлого 0.87 хувь, бусад орлого 0.1 хувь тус тус эзэлж байна.

Нийтийн өргөдлийн цахим системд иргэн Рэгзэнгийн Шинэгэрэлийн байршуулсан РН-202503-75391 дугаартай өргөдлийг дэмжиж саналаа өгсөн 100,187 иргэдийн 85 хувь нь 18-40 насны, 62 хувь нь Улаанбаатар хотын иргэд, 58 хувь нь эмэгтэйчүүд байна.

Дээр дурьдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилгууд, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл

ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.7 болон практик үндэслэл, шаардлагад үндэслэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлсон болно.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Энэ хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын иргэн татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсан болон шилжүүлсний орлого, үйл ажиллагааны орлого, шууд бус орлого болон иргэний бусад орлогод албан татвар ногдуулах хувь, хэмжээг бууруулахад оршино.

Хуулийн төсөл таван зүйлтэй.

Нэгдүгээр зүйлд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан Монгол улсын иргэний төлөх албан татварын хувь хэмжээтэй холбоотой өөрчлөлтийг тусгана.

Хоёрдугаар зүйлд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан албан татварын хувь хэмжээг өөрчилж нэгтгэн найруулсантай холбоотойгоор уг хуулийн зарим зүйлийн хэсэг, заалтуудад дурдагдсан эшлэлийг нийцүүлэн өөрчилнө.

Гуравдугаар зүйлд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан албан татварын хувь хэмжээг өөрчилж нэгтгэн найруулсантай холбоотойгоор уг хуулийн зарим зүйлийн хэсэг, заалтуудад дурдагдсан эшлэлийг хасч өөрчилнө.

Дөрөвдүгээр зүйлд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан албан татварын хувь хэмжээг өөрчилж нэгтгэн найруулсантай холбоотойгоор уг хуулийн зарим зүйлийн хэсэг, заалтыг хүчингүй болгож өөрчилнө.

Тавдугаар зүйлд энэ хууль нь жилийн төсвийн төсөлд төсвийн орлого талд орлогын дүн хасагдаж тооцогдохоор байгаа тул нөлөөллийг 2026 оны төсвийн төсөлд тусгаж, хэрэгжилтийг төсвийн шинэ жилээс эхлэхээр тооцон энэ хуулийн дагаж мөрдөх хугацааг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар:

- Иргэдийн бодит орлого нэмэгдэнэ;

Хувь хүний орлогын албан татвар нь айл өрхийн орлогод бодит ачаалал үүсгэдэг татварын төрөл юм. Статистикийн тоо баримтаас харахад манай улсын

өрхийн сарын дундаж зарлага 2,721,263 төгрөг байгаа бол сарын орлого нь 2,641,671 төгрөг байна. Эндээс харахад өрхийн сарын дундаж зарлага нь орлогоосоо давсан байгаа ба сарын зарлагын бүтцийг харахад өрхийн орлоготой харьцуулахад хоол, унд, хүнсний гэх мэт суурь зардлууд өрхийн зарлагыг голчлон бүрдүүлж байна. Гэтэл гадаад орнуудын хувьд цалин өндөр тул өрхийн орлогын 30% орчим хувийг хоол, хүнс ахуйн суурь зардал, мөн 30% орчмыг нийгэм, соёлын зардлууд эзэлж байгаа бол үлдсэн хэсгийг хуримтлал үүсгэх, хувьцааны зах зээлд оруулах гэх мэтээр хуваарилдаг байна. Гэтэл өрхийн суурь зарлагаа ч бүрэн хангахгүй шахуу байгаа ийм үед хувь хүний орлогын албан татварын өндөр байх нь өрхөд ирэх боломжтой мөнгөн орлогоос багагүй дүн хасагдаж байгаа нь өрхөд шууд дарамт болдог. Иймээс хувь хүний орлогын албан татварыг 1% болгоход өрхийн сарын дундаж орлого 264,150 төгрөгөөр нэмэгдэж, 2,905,821 төгрөг болохоор байна.

- Сүүдрийн эдийн засаг хумигдана;

Хувь хүний орлогын албан татварын хувь өндөр байх үед иргэд орлогоо нууцлах, далд эдийн засаг руу шилжих хандлага нэмэгддэг. Татварын хувь хэмжээг бууруулснаар иргэд орлогоо ил тод тайлагнах сэдэлтэй болж, далд эдийн засгаас албан эдийн засагт шилжих хандлага нэмэгдэнэ. Ингэснээр илүү олон хүн албан ёсоор орлоготой болж, татварын баазад шинээр орж ирнэ.

- Хөдөлмөрийн идэвх сэргэнэ;

Татварын дарамт буурснаар ажиллах сэдэл нэмэгдэж, хүмүүс нэмэлт ажил хийх, илүү хөдөлмөрлөх сонирхолтой болдог. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн зэрэгцээ, нийт орлогын хэмжээ өсөхөд хүргэж, улмаар татварын бааз тэлнэ.

- Ажилчдын цалин хөлс нэмэгдэх боломж нээгдэнэ;

Хувь хүнд буюу ажилтанд ногдох татварын дарамт буурснаар ажил олгогчдын зүгээс ажилтнаа дэмжих, урамшуулах, цалинг нэмэх хандлага бий болно.

- Гадаадын хөрөнгө оруулалтад эерэг мессеж өгнө;

Татварын хувь буурсан үед жижиг, дунд бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ ажлын байр бий болгох сонирхолтой болдог. Энэ нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулагч нарт хүндрэлтэй байгаа ажиллах хүчний асуудлыг шийдэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

- Татвар төлөгчдийн хүрээ тэлнэ;

Үүний үр дүнд татвар төлөгчдийн тоо өсөж, бааз суурь өргөжнө. Лафферийн онолын дагуу татварын хувь хэмжээ буурч дарамт, ачаалал багасахад татварын бааз суурь нэмэгдэж, татвар төлөгчдийн тоо өснө. Татварын хувь хэмжээ багассанаас үүдэж буурсан татварын орлогыг нөхөх байдлаар

татварын хэмжээ тодорхой хэмжээнд нэмэгдэнэ. Хувь хүний орлогын албан татварын хэмжээ буурахад далд эдийн засагт байсан татвар тооцох орлого ил гарснаар нөгөө талдаа Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт эрс дээшилж нийт татварын орлогод эерэг үзүүлэлт бий болно.

- Иргэдийн хувиараа бизнес эрхлэх сонирхол нэмэгдэнэ;

Хувь хүний орлогын албан татварын хүрээнд 7 төрлийн татварын орлогыг хамруулдаг бөгөөд үүнд хувь хүн хувиараа хөдөлмөр эрхлэх замаар олсон орлого ордог. Жишээ нь: хувиараа тээвэр хийх, хоол, төрөл бүрийн үйлчилгээ, зах худалдааны төвүүдэд лангууны худалдаа, ТҮЦ-ний худалдаа эрхлэх гэх мэтээр олон мянган иргэн хөдөлмөр эрхэлж, орлого олж, амь амьжиргаагаа залгуулж байгаа. Эдгээр иргэд олсон орлогоо шударгаар мэдүүлэх хүсэлтэй байдаг бөгөөд цаашид зээл авах, худалдааны болон финтек апп-ууд ашиглах, гадаад улсын визэнд орох зэрэгт орлогоо ил мэдүүлэх шаардлагатай байдаг хэдий ч татварын ачаалал, дарамтаас хамаарч нуух нь их байна. Иймд татварын дарамт эрс буурснаар иргэдийн хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхол нэмэгдэнэ.

- Хөрөнгийн зах зээлд оролцох оролцоо нэмэгдэнэ;

Хүн амын орлогын түвшнээсээ хамааран өрхийн зардлын бүтэц харилцан адилгүй. Ихэнх тохиолдолд орлогоосоо эхний ээлжинд хоол хүнс, ахуйн суурь зардлаа хасаад, нийгэм соёлын зардлаа гаргасны дараа үлдсэн хэсгээс хуримтлал үүсгэх, цаашлаад хөрөнгийн зах зээл дээрээс хувьцаа, бонд худалдан авах хандлага бий болдог. Хувь хүний орлогын албан татвар 1% болсноор дундаас дээш орлоготой өрх хөрөнгийн зах зээлд оролцох оролцоо шууд нэмэгдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар:

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн ба бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ